ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/101/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа
Утас: 99569599

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 369

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.ЦОГБАДРАХ ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4,268.3 мянган төгрөгийг шагнал урамшууралд, эд хариуцагчийн хувийн харилцах дансаар 5,605.0 мянган төгрөгийг Галшар адууны баярт, аймгийн засаг даргын захирамжийг үндэслэн цалингийн зардлаас 2,274.0 мянган төгрөгийг шагналд олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан

- ✓ Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой давхардуулж 1,019.2 төгрөгийг, 3 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 829.0 мянган төгрөгийг илүү олгож , нийт 1,848.2 мянган төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 1,417,647.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 1,196,158.7 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 221,448.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7,283.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 8,527.6 мянган төгрөг, нийт 15,811.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 159,865.1 мянган төгрөгийг зарцуулж, 232.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар 237,261.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 221,488.7 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 1,848.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 12,147.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 110 арга хэмжээ тусгаж, 91.0 хувьтай дүгнэгдсэн байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

*Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл* нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **179,075,175.77** | **116,047,125.77** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 275,900.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 275,900.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 275,900.00 |
| 31212 | Монгол банкин дахь харилцах | - | 275,900.00 |
| **33** | **АВЛАГА** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,325,175.77 | 86,578,725.77 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,767,775.00 | 3,480,375.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 72,706,600.77 | 77,990,950.77 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,898,800.00 | 869,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,286,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,030,000.00 | 1,030,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,922,000.00 | 1,922,000.00 |
| 35600 | Мал амьтад | 61,800,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,243,716,195.20** | **4,271,890,407.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,243,716,195.20 | 4,271,890,407.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,196,906,695.43 | 4,225,090,407.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,512,641,460.00 | 3,798,965,432.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (529,178,977.33) | (684,347,782.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 248,194,800.00 | 296,354,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (149,941,072.94) | (107,643,219.64) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 449,627,753.63 | 407,821,915.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (216,175,317.26) | (281,908,589.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 326,149,244.57 | 330,949,244.57 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (199,976,577.02) | (222,686,825.55) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,001,542,697.80 | 1,001,542,697.80 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (245,977,316.02) | (313,957,265.45) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 46,809,499.77 | 46,800,000.00 |
| 39301 | Програм хангамж | 380,000.00 | 380,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (370,500.23) | (380,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 46,800,000.00 | 46,800,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,422,791,370.97** | **4,387,937,533.27** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,422,791,370.97** | **4,387,937,533.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,422,791,370.97 | 4,387,937,533.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 409,675,576.37 | 409,675,576.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 409,675,576.37 | 409,675,576.37 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,970,542,255.65 | 3,935,688,417.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,970,542,255.65 | 3,970,542,255.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (34,853,837.70) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 42,573,538.95 | 42,573,538.95 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,422,791,370.97** | **4,387,937,533.27** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,023,369,056.00** | **1,806,852,172.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **830,050,599.00** | **373,393,438.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 830,050,599.00 | 373,393,438.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 830,050,599.00 | 373,393,438.93 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 830,050,599.00 | 373,393,438.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,193,318,457.00** | **1,433,458,734.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74,965,357.00 | 15,811,234.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 61,033,845.00 | 7,283,623.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,931,512.00 | 8,527,611.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,118,353,100.00 | 1,417,647,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн | 1,118,353,100.00 | 1,417,647,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,437,072,864.44** | **1,803,789,343.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,437,072,864.44** | **1,803,789,343.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,386,700,350.87 | 1,572,318,035.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 665,363,789.34 | 752,425,406.27 |
| 210101 | Үндсэн цалин | 464,555,717.40 | 375,609,569.02 |
| 210102 | Нэмэгдэл | 117,140,681.97 | 253,588,967.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,385,000.00 | 42,490,037.13 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 79,282,389.97 | 80,736,832.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,005,647.20 | 102,449,473.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,175,748.84 | 74,377,460.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,641,708.14 | 7,940,369.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,024,999.60 | 3,161,512.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,207,799.00 | 3,108,789.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,955,391.62 | 13,861,341.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,764,550.89 | 102,689,908.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,592,585.89 | 24,260,668.99 |
| 210302 | Түлш, халаалт | 69,171,965.00 | 77,478,239.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 951,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,705,995.00 | 99,568,083.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,355,800.00 | 3,997,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,475,355.00 | 27,878,133.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,112,000.00 | 2,354,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,437,840.00 | 3,538,350.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,325,000.00 | 61,800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 130,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 130,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,890,552.00 | 33,099,486.68 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 366,000.00 | 519,986.68 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 253,000.00 | 393,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,271,552.00 | 32,185,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,850,000.00 | 23,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,850,000.00 | 23,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 38,964,791.00 | 69,944,324.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,855,506.00 | 63,790,619.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,012,250.00 | 1,014,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,408.00 | 343,752.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 120,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 730,000.00 | 737,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,095,627.00 | 3,938,953.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 411,155,025.44 | 389,011,353.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 127,429,253.00 | 59,887,080.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,668,900.00 | 3,486,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 282,056,872.44 | 325,638,273.21 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50,372,513.57 | 231,471,308.87 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,148,801.00 | 9,750,326.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 306,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,590,456.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,252,345.00 | 9,750,326.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох** | 32,223,712.57 | 221,720,982.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,223,712.57 | 221,720,982.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **586,296,191.56** | **3,062,829.04** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 37,916,666.74 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 37,916,666.74 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (37,916,666.74) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **586,296,191.56** | **(34,853,837.70)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,198,131,847.00** | **1,433,458,734.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,198,131,847.00** | **1,433,458,734.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 79,778,747.00 | 15,811,234.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,033,845.00 | 7,283,623.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,744,902.00 | 8,527,611.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,118,353,100.00 | 1,417,647,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,118,353,100.00 | 1,417,647,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,193,417,907.00** | **1,433,182,834.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,193,417,907.00** | **1,433,182,834.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,143,993,678.43** | **1,199,142,425.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 668,709,293.85 | 754,494,602.85 |
| 210101 | Үндсэн цалин | 366,786,094.75 | 365,527,998.48 |
| 210102 | Нэмэгдэл | 200,093,890.93 | 270,108,563.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,904,783.49 | 43,063,470.50 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 92,924,524.68 | 75,794,570.07 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,660,142.69 | 96,610,276.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,794,329.51 | 70,520,597.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,361,541.16 | 7,381,913.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,888,216.11 | 3,199,858.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,207,799.00 | 2,856,224.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,408,256.91 | 12,651,681.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,764,550.89 | 102,689,908.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,592,585.89 | 24,260,668.99 |
| 210302 | Түлш, халаалт | 69,171,965.00 | 77,478,239.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 951,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,290,425.00 | 37,588,083.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,843,300.00 | 3,718,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,126,325.00 | 27,878,133.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,760,000.00 | 2,354,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,042,760.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,518,040.00 | 3,637,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,807,100.00 | 2,653,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,807,100.00 | 2,653,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,060,852.00 | 55,671,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,344,000.00 | 15,855,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 943,000.00 | 308,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,773,852.00 | 39,507,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 24,026,000.00 | 23,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,026,000.00 | 23,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 47,106,791.00 | 73,473,224.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 43,997,506.00 | 67,319,519.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,012,250.00 | 1,014,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,408.00 | 343,752.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 120,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 730,000.00 | 737,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,095,627.00 | 3,938,953.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 138,568,523.00 | 52,961,530.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,899,623.00 | 48,206,530.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,668,900.00 | 4,755,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,424,228.57** | **234,040,408.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,200,516.00 | 12,319,426.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 306,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,590,456.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,304,060.00 | 12,319,426.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 32,223,712.57 | 221,720,982.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,223,712.57 | 221,720,982.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,713,940.00** | **275,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,000,000.00** | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,000,000.00** | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,000,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,000,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,000,000.00)** | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (286,060.00) | 275,900.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 275,900.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 409,675,576.37 | 42,573,538.95 | 3,970,542,255.65 | 4,422,791,370.97 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **409,675,576.37** | **42,573,538.95** | **3,970,542,255.65** | 4,422,791,370.97 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **409,675,576.37** | **42,573,538.95** | **3,970,542,255.65** | 4,422,791,370.97 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **409,675,576.37** | **42,573,538.95** | **3,970,542,255.65** | 4,422,791,370.97 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **409,675,576.37** | **42,573,538.95** | **3,970,542,255.65** | 4,422,791,370.97 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (34,853,837.70) | (34,853,837.70) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **409,675,576.37** | **42,573,538.95** | **3,935,688,417.95** | 4,387,937,533.27 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,417,647,500.00 | 1,196,158,728.13 | 221,488,771.87 | 84.38 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,417,647,500.00 | 1,196,158,728.13 | 221,488,771.87 | 84.38 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,411,997,500.00 | 1,191,773,402.13 | 220,224,097.87 | 84.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 817,348,000.00 | 754,494,602.85 | 62,853,397.15 | 92.31 |
| 210101 | Үндсэн цалин | 406,200,000.00 | 365,527,998.48 | 40,672,001.52 | 89.99 |
| 210102 | Нэмэгдэл | 281,068,000.00 | 270,108,563.80 | 10,959,436.20 | 96.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,080,000.00 | 43,063,470.50 | 15,016,529.50 | 74.15 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 72,000,000.00 | 75,794,570.07 | (3,794,570.07) | 105.27 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 102,168,500.00 | 96,610,276.77 | 5,558,223.23 | 94.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,474,600.00 | 70,520,597.73 | (1,045,997.73) | 101.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,173,500.00 | 7,381,913.88 | 791,586.12 | 90.32 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,086,700.00 | 3,199,858.69 | 886,841.31 | 78.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,086,700.00 | 2,856,224.95 | 1,230,475.05 | 69.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,347,000.00 | 12,651,681.52 | 3,695,318.48 | 77.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 152,242,500.00 | 102,689,908.51 | 49,552,591.49 | 67.45 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 62,546,100.00 | 24,260,668.99 | 38,285,431.01 | 38.79 |
| 210302 | Түлш, халаалт | 86,896,400.00 | 77,478,239.52 | 9,418,160.48 | 89.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,800,000.00 | 951,000.00 | 1,849,000.00 | 33.96 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,621,400.00 | 32,833,950.00 | 5,787,450.00 | 85.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,169,200.00 | 3,519,600.00 | 649,600.00 | 84.42 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,100,000.00 | 23,929,000.00 | 4,171,000.00 | 85.16 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,500,000.00 | 2,178,000.00 | 1,322,000.00 | 62.23 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,045,000.00 | - | 1,045,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,807,200.00 | 3,207,350.00 | (1,400,150.00) | 177.48 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,807,100.00 | 2,653,000.00 | 2,154,100.00 | 55.19 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,807,100.00 | 2,653,000.00 | 2,154,100.00 | 55.19 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,093,000.00 | 55,671,800.00 | (1,578,800.00) | 102.92 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,149,900.00 | 15,855,700.00 | 294,200.00 | 98.18 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 943,100.00 | 308,600.00 | 634,500.00 | 32.72 |
| 210604 | Урсгал засвар | 37,000,000.00 | 39,507,500.00 | (2,507,500.00) | 106.78 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 27,200,000.00 | 21,600,000.00 | 5,600,000.00 | 79.41 |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,200,000.00 | 21,600,000.00 | 5,600,000.00 | 79.41 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам** | 146,419,200.00 | 72,258,334.00 | 74,160,866.00 | 49.35 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төл | 139,296,200.00 | 66,554,629.00 | 72,741,571.00 | 47.78 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 622,800.00 | - | 622,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,000.00 | 300.00 | 99.97 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 536,400.00 | 343,752.00 | 192,648.00 | 64.09 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 245,600.00 | 120,000.00 | 125,600.00 | 48.86 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 740,400.00 | 287,000.00 | 453,400.00 | 38.76 |
| 210807 | Газрын төлбөр | 3,963,500.00 | 3,938,953.00 | 24,547.00 | 99.38 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 69,097,800.00 | 52,961,530.00 | 16,136,270.00 | 76.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,548,900.00 | 48,206,530.00 | 15,342,370.00 | 75.86 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,548,900.00 | 4,755,000.00 | 793,900.00 | 85.69 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,650,000.00 | 4,385,326.00 | 1,264,674.00 | 77.62 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,650,000.00 | 4,385,326.00 | 1,264,674.00 | 77.62 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,650,000.00 | 4,385,326.00 | 1,264,674.00 | 77.62 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,417,647,500.00 | 1,196,158,728.13 | 221,488,771.87 | 84.38 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,417,647,500.00 | 1,196,158,728.13 | 221,488,771.87 | 84.38 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,417,647,500.00 | 1,196,158,728.13 | 221,488,771.87 | 84.38 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,601,234.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,601,234.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,369,023.00** |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **4,754,133.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 199,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,949,133.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 176,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 430,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **1,400,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,400,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,214,890.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 764,890.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,000,000.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 |
| 2133 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **232,211.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 232,211.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 12,601,234.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,601,234.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,283,623.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,317,611.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 221,488.7 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 221,488.7 мянган төгрөгийг тохируулаагүй алдааг залруулсан.

Аудитаар нийт 13,995.5 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 1,848.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,147.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн байна.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой давхардуулж 1,019.2 мянган төгрөгийг, 3 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 829.0 мянган төгрөгийг илүү олгож, нийт 1,848.2 мянган төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

### 5.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4,268.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд, эд хариуцагчийн харилцах дансаар 5,605.0 мянган төгрөгийг Галшар адууны баярт, нийт 9,873.3 мянган төгрөгийг зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" ,Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Аймгийн засаг даргын захирамжийг үндэслэн цалингийн зардлаас 2,274.0 мянган төгрөгийг шагналд олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

### 5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөөрөө элэгдлээ бүрэн нөхсөн 108 нэр төрлийн 411,882.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Ашиглах боломжтойг дахин үнэлэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг данснаас хасах арга хэмжээг авч ажиллаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1."Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй хөрөнгүүдийн талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дураар зүйлийн 20.5-т ".Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

**Аудитаар илрүүлсэн 13,995.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн тохируулгын тайлан бэтгээгүй | 1 | 221,488.7 | | | 1 | 221,488.7 | 1 | 221,488.7 | | | | |
| **Дүн** | 1 | 221,488.7 | | | 1 | 221,488.7 | 1 | 221,488.7 | 0 | 0,00 | 0 | 0,00 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хөрөнгийн ашиглалт, данснаас хасах, дахин үнэлэх арга хэмжээ аваагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Цалин илүү олгосон | 1 | 1,848.2 | 1 | 1,848.2 | | | | | | | | |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 9,873.3 | | | 1 | 9,873.3 | | | | | | |
| Цалингийн зардлаас шагнал олгосон. | 1 | 2,274.0 | | | 1 | 2,274.0 | | | | | | |
| **Дүн** | **4** | **13,995.5** | 1 | 1,848.2 | 2 | 12,147.3 | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 44- А2371125 ХЭА-2026/101/НА-СТА-ТШЗ Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой давхардуулан 1,019,242.11 (нэг сая арван есөн мянга хоёр зуун дөчин хоёр) төгрөгийг, 3 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 829,000.00 (найман зуун хорин есөн мянга) төгрөгийг илүү олгож , нийт 1,848,242.11 (нэг сая найман зуун дөчин найман мянган хоёр зуун дөчин хоёр) төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох“ журмын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 1,848,242.11 (нэг сая найман зуун дөчин найман мянган хоёр зуун дөчин хоёр) төгрөгийг нягтлан бодогч Ц.Одгэрэлээр төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Цогбадрах-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Д.ЭРДЭНЭТУЯА

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 Дугаар 71-А2371125 Чингис хот
ХЭА-2026/101/НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4,268,350.00 (дөрвөн сая хоёр зуун жаран найман мянга гурван зуун тавь) төгрөгийг шагнал урамшууллалд, эд хариуцагчийн харилцах дансаар 5,605,000.00 (таван сая зургаан зуун таван мянга) төгрөгийг Галшар адууны баярт, нийт 9,873,350.00 (есөн сая найман зуун далан гурван мянга гурван зуун тавь) төгрөгийг зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” ,Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна..

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т “төсвийг зориулалт бусаар зарцуулсан;”, 4.2.1.11-д *“хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хариуцагчийн дансанд мөнгөн хөрөнгө шилжүүлдэг, төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Цогбадрах-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Д.ЭРДЭНЭТУЯА

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 Дугаар 72-А2371125 Чингис хот
ХЭА-2026/101/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн засаг даргын захирамжийг үндэслэн цалингийн зардлаас 2,274,000.00 (хоёр сая хоёр зуун далан дөрвөн мянга) төгрөгийг шагналд олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Цогбадрах-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Д.ЭРДЭНЭТУЯА

Монгол улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, 7056211